



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/238

Алтай хот

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын хугацааг сунгаж зохион
байгуулалтын арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 154 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 31 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үүднээс батлагдсан болон нэгдүгээр хавтал болсон иргэдийг тусгаарлах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Зоонозын өвчин судлалын төвд тус тус даалгаж, хууль ёсны шаардлага биелүүлээгүй иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцуулж ажиллахыг даалгасугай.

3. Хөхморьт, Цээл сумдыг "Улаан түвшин"-д шилжүүлж, Тайшир, Жаргалан сумдыг Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга нарт тус тус даалгасугай.


2.

4."Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ын тусгай нөхцөл шаардлагын дагуу зах, худалдааны төв, хүнс, барааны дэлгүүр, хоол, үсчин, оёдол, болон авто болон дугуй засварын үйлчилгээг өдрийн 10:00-18:00 цагийн хооронд халдвар хамгааллын дэглэмийг сахиулан зохион байгуулах, архи, согтууруулах ундааг худалдахыг хориглож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (хурандаа Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газрын (Н.Сумъяабазар), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5.Улаанбаатар хот болон бусад аймгаас ирэх иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж, холбогдох журмын дагуу зохион байгуулахыг Онцгой байдлын газар (хурандаа З.Баттулга), Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР